

ЗӨВЛӨМЖ

МАЛЫН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТУХАЙ

2004 оны 03 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулиар 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 123¹ дүгээр зүйл буюу “мал хулгайлах” гэмт хэргийг бие даасан зүйл, хэсэг болгон хуульчлаагүй бөгөөд уг гэмт хэргийг Эрүүгийн шинэ хуулийн 145 дугаар зүйл буюу “бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэгт хамааруулсан юм.

Эрүүгийн хуучин хуулийн 123¹ дүгээр зүйл нь биеэ даасан зүйл, хэсэгтэй ял шийтгэлийг хүндрүүлэн авч үзэх хэд хэдэн бүрэлдэхүүнтэй, ялын санкци нь зөвхөн хорих ялтай байжээ. Хууль тогтоогч ийнхүү малын хулгайн гэмт хэргийг Эрүүгийн хуучин хуульд бие даасан зүйл, хэсэг болгон тусгайлан авч үзэж байсан нь мал, малын ашиг шим малчдын амьдралын эх үүсвэр болж байдаг онцлог нөхцөл байдалтай холбож тайлбарладаг бөгөөд одоо ч энэ байдал хэвээрээ байна.

Монгол Улсын шүүх 1999 онд малын хулгайн 904 гэмт хэрэгт 1320 хүн, 2000 онд 1011 хэрэгт 1474 хүн, 2001 онд 1142 хэрэгт 1634 хүн, 2002 онд /хуучин хуулиар/ 1002 хэрэгт 1496 хүн ял шийтгүүлснээс үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил бүр өссөн бөгөөд малын хулгайн гэмт хэрэгт ял шийтгүүлэгсдийн хорих ялын биечлэн эдлүүлэлтийн улсын дундаж сүүлийн 3 жилд 54,7 хувь байжээ.

Малын хулгайн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлт жилээс жилд ийнхүү өсөж байгаа болон энэ төрлийн гэмт хэргийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хамааруулснаар, мал хулгайлсан гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн байдлыг судлаж мал хулгайлсан хэрэгт баримтлах ялын бодлогыг оновчтой зөв тодорхойлох зорилгоор 2003 онд малын хулгайн гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн байдлыг улсын хэмжээгээр нэгтгэж судлав.

Судалгаанд бүх сум буюу сум дундын, дүүргийн шүүх хамрагдсан бөгөөд 2003 онд улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэсэн малын хулгайн гэмт хэрэг 463 байгаа нь 2003 онд шүүхээр шийдвэрлэсэн бүх гэмт хэргийн 7.8, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан бусдын өмч хулгайлах гэмт хэргийн 20.6 хувь болж байна.

Малын хулгайн гэмт хэрэг үйлдэгсдийн 80 орчим хувь нь эрхэлсэн ажилгүй, урьд нь өмчийн эсрэг болон энэ төрлийн гэмт хэрэгт 1-3 удаа ял шийтгүүлсэн хүмүүс байгаагаас үзвэл малын хулгайн гэмт хэрэг үйлдэгсдэд оногдуулах ялын бодлогыг ямар ч тохиолдолд сулруулахгүй байх шаардлага хэвээр байгааг харуулж байна.

Малын хулгайн гэмт хэргийг шийдвэрлэсэн байдлыг 2002 оныг 2003 онтой харьцуулан шүүх тус бүрээр судлан үзвэл:

Д/д	Шүүх	Хэрэг		Ял шийтгүүлэгсэд		Хорих ял		Хорих ялын биелэн эдлүүлэлт		Хорих ял биелэн эдлүүлэлтийн хувь		Баривчлах ял
		2002	2003	2002	2003	2002	2003	2002	2003	2002	2003	
1	Архангай	51	47	75	79	63	54	36	24	48	44.4	23
2	Баян-Өлгий	32	17	56	55	51	28	30	23	53.6	82.1	11
3	Булган	66	29	76	58	72	43	52	12	68.4	27.9	12
4	Баянхонгор	26	13	33	24	33	13	16	8	48.5	61.5	7
5	Говь-Алтай	25	10	32	22	27	9	12	8	37.5	88.9	11
6	Говьсүмбэр	9	5	18	8	12	5	8	3	44.4	60	3
7	Дархан-Уул	42	22	57	36	46	18	26	11	45.6	61.1	11
8	Дорнод	59	14	90	36	79	29	49	20	54.4	69	8
9	Дорноговь	34	15	44	29	37	19	21	15	47.7	78.9	8
10	Дундговь	28	24	32	42	25	21	19	7	59.4	33.3	7
11	Завхан	50	16	75	29	50	10	38	3	50.7	30	17
12	Өвөрхангай	72	22	108	50	84	33	64	18	59.3	54.5	10
13	Өмнөговь	29	9	47	18	38	9	25	4	53.2	44.4	9
14	Сэлэнгэ	71	11	119	26	114	14	70	3	58.8	21.4	5
15	Сүхбаатар	34	16	59	20	57	13	22	13	37.3	100	7
16	Төв	49	37	67	65	61	46	22	23	32.8	50	11
17	Нийслэл	37	21	75	51	73	46	41	30	54.7	65.2	3
18	Увс	74	34	109	72	76	36	54	19	49.5	52.8	27
19	Хөвсгөл	88	67	135	123	117	82	65	29	48.1	35.4	27
20	Ховд	38		55		39		29		52.7		
21	Хэнтий	76	23	104	58	94	43	68	36	65.4	83.7	11
22	Орхон	12	11	30	24	30	18	21	10	70	55.6	1
	Бүгд	1002	463	1496	925	1278	589	788	319	52.7	58.9	229

Малын хулгайн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг дээрх 2 оноор харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд уг гэмт хэргийн шийдвэрлэлт бүх шүүхүүдэд бараг 20-50%-иар буурсан дүн харагдаж байна.

Харин ял шийтгэл, түүний дотор хорих ялын биелэн эдлүүлэлтийн хувь хэмжээ төдийлөн буураагүй байгаа боловч Эрүүгийн шинэ хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2 дах хэсэгт баривчлах ялыг оруулсантай холбогдуулан шүүхээс баривчлах ялыг оногдуулах явдал түгээмэл байна.

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ бэлчээрт явсан малыг машин, мотоцикл ашиглан хулгайлах, мөн бүлэглэх болон урьдчилан тохиролцож бүлэглэн хулгайлж байгаа бөгөөд хулгайлсан малын дотор гойд ашиг шимтэй мал, хурдан удмын адуу байхаас гадна тухайн айлын амьжиргааг залгуулах гол эх үүсвэр болсон мал сүргийг хотыг нь харлуулан бүгдийг нь хулгайлсан хэрэг олноор үйлдэгдэж байна. Иймд малын хулгайн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахдаа ял шийтгэлийн цээрлүүлэх ач холбогдлыг илүү анхаарах шаардлага зүй ёсоор гарч байгааг тэмдэглэж байна.

Мөн хулгайлсан малын үнэлгээг тогтоохдоо тухайн орон нутгийн үнэ ханшийг харгалзахаас гадна уг малын удам, үүлдэр угсаа, хээлтэй эсвэл нялх төлтэй байсан зэргийг харгалзан ялгамжтай үнэлж байвал зохино.

Энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ шүүх дорхи алдаа зөрчлийг гаргаж байна:

1. Шүүх хуульд байхгүй зүйл, хэсгээр ял оноож байна. Жишээ нь: Багануур дүүргийн шүүх 2003 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 6 дугаар шийтгэх тогтоолоор Ц.Хатанбаатар гэгч этгээдэд холбогдох хулгайн хэргийг шийдвэрлэхдээ шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа буюу оныг “2001, 2002 он” гэж өөр, өөр бичсэн, мөн тодорхойлох, тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1.2 гэж хуульд байхгүй хэсгээр ял оноожээ.

2. Мөн шүүхүүд шүүхийн шийтгэх тогтоолд тухайн хэргийн улмаас учирсан нийт хохирлын хэмжээг тодорхойлон заадаггүй дутагдлыг нийтлэг гаргаж байна.

3. Хорих ял шийтгүүлсэн этгээдийн ял эдлэх дэглэмийг тогтоохдоо хуулийн зүйл хэсгийг буруу баримтлах, буруу тогтоох, дэглэм хөнгөрүүлсэн үндэслэл шалтгаанаа шийтгэх тогтоолд бичихгүй байх зөрчил түгээмэл гарчээ.

Түүнчлэн шүүхүүд шүүгдэгчийн ял эдлэх дэглэмийг хөнгөрүүлэх буюу чангаруулж тогтоохдоо Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсгийг мөн зүйлийн зохих хэсэгтэй давхар баримтлахгүйгээр 52.10 дахь хэсгийг дангаар баримтлан шийдвэрлэж байна.

Жишээ нь: Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6-д “Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтны ... хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ” гэж заасан байхад Багануур дүүргийн шүүх 2003 оны 84 дүгээр шийтгэх тогтоолоор Ц.Батбаяр гэгчийн хорих ялын дэглэмийг мөн зүйл ангийг баримтлан жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр тогтоосон, мөн тус шүүх 2003 оны 61 дүгээр шийтгэх тогтоолоор насанд хүрсэн Ж.Цогтбаатарын хорих ялыг Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.8-д заасан насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэж хуулийн заалт зөрчсөн байна.

Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 125 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Ц.Ганбаатарын эдлэх ялыг жирийн дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсгийг баримтлах ёстой байхад хорих ял гэж юу вэ гэдгийг тодорхойлсон хэсэг буюу 52.1 дэх хэсгийг баримталж хуулийн заалт буруу хэрэглэжээ.

4. Зарим шүүх шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт тухайн шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн талаар тодорхой дурьдахгүй байгаа нь ЭБШХ-ийн 296 дугаар зүйлийн 296.1 дэх хэсэгт “Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримтыг ... тодорхойлно” гэж заасан заалтыг зөрчиж байна.

Тухайлбал, Хэнтий аймгийн сум дундын 1 дүгээр шүүх 2003 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар шийтгэх тогтоолоор Аймгийн Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.3, 261 дүгээр зүйлийн 261.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Д.Лхасүрэн, Ц.Олзбат нарт холбогдох хэргийг шийдвэрлэхдээ тогтоолын тодорхойлох хэсэгт Д.Лхасүрэн, Ц.Олзбат нарын зөвхөн мал хулгайлсан гэмт хэргийн талаар тодорхойлсон ба тэдний оргосон гэмт хэргийнх нь талаар огт дурьдаагүй атлаа тогтоолын тогтоох хэсэгт Д.Лхасүрэнг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт зааснаар 5 жил 05 хоног хорих ялаар, мөн хуулийн 261 дүгээр зүйлийн 261.1 дэх хэсэгт зааснаар 1 жил хорих ял тус тус оногдуулсан байна.

5. Зарим шүүх гэмт хэрэг үйлдсэн арга, учруулсан хохирол, шүүгдэгчийн хувийн байдал, хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, дүгнэлт хийхгүйгээр баривчлах ялыг хавтгайруулан хэрэглэж байна.

Судалгаанаас үзэхэд Архангай, Хөвсгөл, Увс аймгийн шүүхүүд баривчлах ялыг хамгийн их оногдуулсан байна. Малын хулгайн гэмт хэрэгт шийтгүүлэгсдийн дийлэнх нь урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлж байсан этгээдүүд, шүүхээр малын хулгайн хэрэгт ял шийтгүүлэгсдийн ихэнх нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсгээр ял шийтгүүлж байгаа бөгөөд шүүх энэ зүйлд заасан ял шийтгэлийг оногдуулахдаа хэргийн зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлэн өөрчлөх, хөнгөн ял оногдуулах зэргээр хууль зөрчиж байна.

Тухайлбал: а/ Дорноговь аймгийн сум дундын шүүх 2000 оны 22 тоот таслан шийдвэрлэх тогтоолоор “Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар оногдуулсанг 3 жилийн хорих ялыг тэнсэж 2 жилийн хугацаагаар хянан харгалзсан байсан” Х.Өлзийбат гэгчид мөн аймгийн сум дундын 1 дүгээр шүүх 2003 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 98 дугаар шийтгэх тогтоолоор бусдын 3 адууг хулгайлсан /хохилогч 1 адуугаа хурдан удмын адуу гэж мэдүүлсэн/ гэмт хэрэгт нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт зааснаар 3 сарын баривчлах ялаар шийтгэсэн,

б/Увс аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 71 дүгээр шийтгэх тогтоолоор бусдын 1 сая 90000 төгрөгийн үнэ бүхий 12 тэмээг мотоцикл ашиглан хулгайлсан, хохиролоо төлөөгүй Д.Дүгэрсүрэн гэгчид Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт зааснаар 3 сарын хугацаагаар баривчлах ял оногдуулсан,

в/Мөн шүүх 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 114 дүгээр шийтгэх тогтоолоор бусдын 14 хонийг О.Батжаргал гэгчтэй бүлэглэн хулгайлсан Д.Батцэрэнд Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар 6 сарын баривчлах ял шийтгэсэн байх бөгөөд Д.Батцэрэн гэгч нь 2002 оны 6 дугаар сард Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ял шийтгүүлсэн байхад ялыг нэмж нэгтгэх эсэх, зүйлчлэл зөв эсэхэд дүгнэлт хийгээгүй төдийгүй энэ шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт Д.Батцэрэнгийн шийтгэгдэж байсан ялын төрөл, хэмжээний талаар тодорхой бичээгүй зөвхөн “ял шийтгэлтэй, 2002 оны 6 дугаар сард Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ял шийтгэгдэж байсан” гэсэн нь ойлгомжгүй болжээ.

г/Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх 2003 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 6 дугаар шийтгэх тогтоолоор Л.Отгонжаргал гэгч нь иргэн Т.Лхагваагийн 3 адууг ганцаараа, Б.Сүхбаатар гэгчтэй бүлэглэн иргэн Чулуунсайханы 13 адууг, Л.Алтангэрэлтэй бүлэглэн бусдын 3 байдсыг, Б.Сүхбаатар гэгч нь нь ганцаараа бусдын 2 адуу хулгайлж, нийт 1590000 төгрөгийн хохирол учруулсан хэрэг үйлдсэн, хохирлын заримыг төлөөгүй байхад Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-д зааснаар шүүгдэгч нарыг тус бүр зургаан сарын баривчлах ялаар шийтгэсэн байна,

д/Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх 2003 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/01 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн, шүүгдэгч П.Адъяацоодол, 2000 оны 05 дугаар сарын 02-нд Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 2-т зааснаар 1 жилийн хорих ялыг тэнсэж мөн хугацаагаар хянан харгалзахаар тогтоогдож байсан Д.Нямдорж нар нь 2002 оны 06 дугаар сард иргэн Юндэнгийн 4 тооны адуу хулгайлсан, хохирлоо төлж барагдуулаагүй байхад 1986 оны Эрүүгийн хуулийн 123¹ дүгээр зүйлийн 2-т зааснаар Д.Нямдоржийг 200000 төгрөг, П.Адъяацоодолыг 100000 төгрөгөөр торгож шийтгэсэн байх бөгөөд зүйлчлэлийг өөрчлөхдөө “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3-т зааснаар зүйлчилснийг хүчингүй болгосугай” гэж бичиж хуульд заагаагүй нэр томъёо хэрэглэсэн байна.

6/ Шүүхээс гаргаж байгаа эрх зүйн акт, баримт бичигт туйлын хайхрамжгүй хандаж байна.

Тухайлбал: Өвөрхангай аймгийн сум дундын шүүх шийтгэх тогтоолын тогтоох хэсэгтээ ЭБШХ-ийн 286 дугаар зүйлийн 286.1.11, 297 дугаар зүйлийн 297.1.4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэх талаар огт дурьддаггүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээсэн, батлан даалтанд өгсөн эсэх нь тодорхой биш, нийт шүүх торгох ялын хэмжээг давхар тоон дүнгээр илэрхийлдэггүй, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн төгрөгөөр торгосугай гэх мэтээр бичих, торгуулийн ялаас ноцтойгоор зайлсхийвэл хорих ялаар солихыг заадаггүй, тэнсэж хянан харгалзсан хугацаанд шүүгдэгчийн засрал хүмүүжилд хэн хяналт тавихыг нь заахгүй орхих зэрэг зөрчлийг нэг биш удаа гаргажээ.

Мөн Увс аймгийн сум дундын шүүхийн шүүгч Ч.Элдэв-Очирын даргалсан 2003 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 67 дугаар шийтгэх тогтоолтой, шүүгдэгч М.Рэнцэнсамбуу, Г.Төрбат нарт холбогдох хэргийг шийдвэрлэсэн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 7-д: “Монгол Улсын Дээд шүүхийн 2000 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн ...” гэж бичсэн байгаа нь шүүгч хүн гаргаж болохооргүй алдаа мөн бөгөөд Дээд шүүх хууль батлан гаргадаггүй гэдгийг мэдэхгүй байгаа нь туйлын хариуцлагагүй явдал юм.

Харин Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3, 145.4 дэх хэсэгт зааснаар оногдуулж байгаа ял шийтгэл тохирсон, ялын бодлогын тэнцвэр тогтвортой байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэв.

Дээрхи судалгааны дүнг үндэслэн Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйл /малын хулгайн хэрэг/-д заасан хэргийг шийдвэрлэхэд гарч буй алдаа, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, энэ төрлийн гэмт хэрэг, түүнд оногдуулах ял шийтгэлийг ялгамжтай, хуулийн үндэслэлтэй оногдуулах явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 72 дугаар зүйлийг удирдлага болгон **Зөвлөмжлөх нь** :

1.Малын хулгайн гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн бодлогыг сулруулахгүйгээр, энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлэгсдэд оногдуулах ялыг ялгамжтай, зөв тэнцвэртэй оногдуулах, хуулийн үндэслэлгүйгээр хавтгайруулан тэнсэх, ял хойшлуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан ялын аль хөнгөн төрлийг сонгон хэрэглэх, зарим тохиолдолд олон үйлдэлтэй их хэмжээний хохирол учруулсан хэрэгт нь хөнгөн ял шийтгэл оногдуулах, үйлдэл цөөнтэй, хохирлын хэмжээ бага хэрэгт хүнд ялаар шийтгэх зэрэг зохисгүй дутагдлыг таслан зогсоох, малын хулгайн хэрэгт ялын бодлого алдагдуулах хандлага гарч байгааг цаашид анхаарч засах.

2.Хорих ял эдлэх дэглэмийг тогтоохдоо Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн хэсэг, заалтыг зөв баримталж хэвших.

Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Шүүх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хорих ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлж буюу чангаруулан өөрчилж болно. Ийнхүү шийдвэрлэсэн шалтгааныг шийтгэх тогтоолд заана” гэсэн заалтыг хэрэглэхдээ гэмт этгээдийн үйлдсэн хэргийн болон хувийн байдалд онцгой анхаарч, дэглэмийг өөрчлөх болсон үндэслэлээ шийтгэх тогтоолын үндэслэх хэсэгт нэг бүрчлэн зааж байхаас гадна тухайн этгээдийн ял эдэлбэл зохих дэглэмийг заасан хэсгийг Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгтэй давхар баримталж байвал зохино.

3.Малын хулгайн гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоохдоо тухайн орон нутгийн зах зээлийн үнэ ханш, хохирогч алдсан малаа хайхад зарцуулсан зардал, хулгайд алдсан мал хээлтэй, нялх төлтэй, ашиг шим ихтэй байсан зэрэг онцлог нөхцөл байдлыг харгалзан хохирол төлбөрийг гаргуулж байх.

4.Шүүхээс гаргаж буй тогтоол, шийдвэрийг ЭБШХ-ийн 294-297 дугаар зүйлийн шаардлагад нийцүүлэн, хууль зүйн үндэслэлтэй, үг, найруулгын хувьд алдаагүй, албан бичиг, бичиг хэргийн стандартыг баримтлан үйлдэж байх, /ялангуяа Сүхбаатар, Орхон, аймгийн шүүх/ энэ талаар анхаарч ажиллах.

5.Дээрхи судалгаанд дурьдагдсан алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй, гаргасан тогтоол, шийдвэрээ нягтлан хянаж ажиллахыг нийт шүүхийн шүүгчдэд зөвлөж байна

6.Мал хулгайлсан гэмт хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг жил бүр судлан үзэж дүгнэлт гаргаж ажиллахыг сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүдийн болон аймаг, нийслэлийн шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт мэдэгдэж энэ тухай мэдээлэлийг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Шүүхийн Судалгааны төвд ирүүлж байхыг даалгаж байна.

**ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ӨАÍÕÈ**